



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2020

Э-сонин

12-Р САР

89-р дугаар






Үнэт цаасны зах зээлийн тойм мэдээ

Зах зээлийн тойм


/2020.12.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	22
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	14,673,215,398.65
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	14,293,165,020.91
Багцын арилжаа	4,153,336,843
Хөрөнгө орцлалтын сан /хоёрдогч/	48,782,347.74
Компанийн бонд /хоёрдогч/	331,268,030
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	100,336,225
Хувьцаа /анхдагч/	0
Хувьцаа /хоёрдогч/	99,872,048
Багцын арилжаа	52,231,019
Хөрөнгө орцлалтын сан /хоёрдогч/	460,876
Компанийн бонд /хоёрдогч/	3,301
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	6,517


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	192
100% төрийн өмчит	17
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	165
I ангилал	18
II ангилал	42
III ангилал	134

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	54
Үүнээс: Брокер, Дилер	54
Андеррайтер	19
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



Үнэт цаасны зах зээлийн тойм мэдээ

Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2020.12.31-ний байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	БИДИСЕК ХК	30,739,644.00	3,580,225,983.10	34,571,490	3,940,344,963.40	7,520,570,947
2	ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	2,406,482.00	5,175,691,851.32	2,363,060	194,275,895.33	5,369,967,747
3	АРД СЕКЮРИТИЗ ХХК	23,199,893.00	3,219,913,540.80	17,829,724	2,096,233,377.71	5,316,146,919
4	БУЛГАН БРОКЕР ХХК	75,797.00	28,044,890.00	610,134	5,182,936,373.20	5,210,981,263
5	МИРЭ ЭССЕТ СЕКЮРИТИС МОНГОЛ ХХК	31,350,052.00	1,264,950,685.29	15,077,830	770,464,816.22	2,035,415,502
6	БУМБАТ-АЛТАЙ ХХК	1,312,098.00	652,967,467.22	8,321,881	1,065,135,980.03	1,718,103,447
7	РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК	4.00	404,040.00	17,443,125	540,387,590.64	540,791,631
8	АПЕКС КАПИТАЛ ҮЦК	1,588,882.00	100,663,071.73	1,135,968	289,764,530.02	390,427,602
9	ГҮҮДСЕК ХХК	6,324,796.00	280,097,564.37	24,257	2,033,493.14	282,131,058
10	ГОЛОМТ КАПИТАЛ ХХК	959,132.00	108,259,313.30	584,495	135,056,123.06	243,315,436
11	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК	734,631.00	63,953,433.42	892,614	141,152,220.98	205,105,654
12	ГАУЛИ ХХК	389,473.00	27,838,875.32	393,596	130,058,995.20	157,897,871
13	АРД КАПИТАЛ ГРУПП ХХК	495,871.00	30,352,778.44	214,639	29,906,761.92	60,259,540
14	БЛҮМСБЮРИ СЕКЮРИТИЕС ХХК	194,347.00	32,227,956.14	80,866	14,070,735.00	46,298,691
15	МОНСЕК ХХК	98,681.00	15,840,164.81	90,570	21,272,025.88	37,112,191
16	ЗЭРГЭД ХХК	48,348.00	8,704,660.00	132,453	25,658,317.10	34,362,977
17	ГАЦУУРТ ТРЕЙД ХХК	67,810.00	29,796,590.00	0.00	-	29,796,590
18	ЭС ЖИ КАПИТАЛ ХХК	0.00	-	67,500	29,695,000.00	29,695,000
19	ГРАНДДЕВЕЛОПМЕНТ ХХК	160,008.00	10,045,777.92	61,563	13,326,212.10	23,371,990
20	ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК	6,244.00	18,118,267.25	39,290	4,193,361.32	22,311,629

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2020.12.31-ний байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /% /
1	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	34,610,142	1,041,604,481	36.50	28.50	9.93
2	BODI	БОДЬ ДААТГАЛ ХК	20,846,586	2,510,679,149	132.00	120.00	-1.52
3	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	19,512,744	1,481,009,291	84.00	66.25	22.35
4	JTB	ЖЕНКО ТУР БЮРО ХК	9,163,489	870,291,001	93.00	81.11	5.95
5	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ ХК	8,884,252	401,130,741	49.99	47.00	-1.25
6	NEH	ДАРХАН НЭХИЙ ХК	1,899,194	27,594,575	15.20	14.20	-0.13
7	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХК	985,670	591,416,320	660.00	595.00	-3.76
8	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК	665,040	1,029,635,565	1,800.00	1,350.00	25.48
9	APU	АПУ ХК	635,354	377,407,072	630.00	570.00	4.63
10	XOC	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН ХК	460,876	48,782,367	115.00	104.20	3.34
11	MIK	МИК ХОЛДИНГ ХК	422,218	5,067,381,640	14,960.00	11,000.00	35.91
12	TUM	ТҮМЭН ШУВУУТ ХК	364,740	58,069,352	181.00	151.00	7.85
13	AIC	АРД ДААТГАЛ ХК	314,157	233,972,600	800.00	686.00	13.58
14	MFC	МОНОС ХҮНС ХК	293,031	19,394,313	68.29	64.50	-0.98
15	BUN	БУЛГАН УНДРАГА ХК	236,774	1,601,726,223	760.8	500.25	74.90
16	GOV	ГОВЬ ХК	173,320	32,962,687	193.80	187.10	1.32
17	RMC	РЕМИКОН ХК	157,056	3,686,771	25.98	22.00	-7.77
18	ITLS	АЙТҮҮЛС ХК	98,996	7,760,024	87.00	70.03	6.86
19	SHG	ШАРЫН ГОЛ ХК	89,313	71,471,296	899.99	750.00	13.62
20	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	81,010	54,382,221	750.00	581.02	25.00



Үнэт цаасны зах зээлийн тойм мэдээ

Ханшийн өсөлттэй хувьцаа

/2020.12.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт /% /
			2020-12-01	2020-12-31		
1	БУЛГАН УНДРАГА ХК	236,774	435	760.80	325.80	74.90
2	ХӨХ ГАН ХК	27,631	55.01	74.99	19.98	36.32
3	МИК ХОЛДИНГ ХК	422,218	11000	14,950.00	3,950.00	35.91
4	ТЕХНИК ИМПОРТ ХК	3	6900	8,740.00	1,840.00	26.67
5	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК	665,040	1401	1,758.00	357.00	25.48
6	МОНГОЛ ШУУДАН ХК	81,010	600	750.00	150.00	25.00
7	МОНИНЖБАР ХК	14,690	80	99.95	19.95	24.94
8	БИ ДИ СЕК ХК	2,839	791.5	988.00	196.50	24.83
9	АРД КРЕДИТ ББСБ ХК	19,512,744	67.1	82.10	15.00	22.35
10	ЭРДЭНЭС СОЛЮШИНС ХК	67,605	440	529.00	89.00	20.23
11	БАЯНТЭЭГ ХК	10	21260	25,500.00	4,240.00	19.94
12	МОГОЙН ГОЛ ХК	218	6200	7,245.00	1,045.00	16.85
13	МОНГОЛ АЛТ ХК	1	7270	8,360.00	1,090.00	14.99
14	ТҮШИГ УУЛ ХК	160	820	940.00	120.00	14.63
15	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	3,185	450	515.00	65.00	14.44
16	ТАВАН ТОЛГОЙ ХК	12,441	6175	7,060.00	885.00	14.33
17	АВТО ИМПЕКС ХК	38	950	1,085.00	135.00	14.21
18	ШАРЫН ГОЛ ХК	89,313	778.2	884.17	105.97	13.62
19	АРД ДААТГАЛ ХК	314,157	704.32	799.96	95.64	13.58
20	МАТЕРИАЛИМПЕКС	41	7000	7,800.00	800.00	11.43

Ханшийн бууралттай хувьцаа

/2020.12.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2020-12-01	2020-12-31		
1	ОЛЛОО ХК	29,332	45.1	34.80	-10.30	-22.84
2	ТАХЬ-КО ХК	2	14500	12,330.00	-2,170.00	-14.97
3	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ	5,082	104.36	90.01	-14.35	-13.75
4	ДӨРВӨН-УУЛ ХК	12	550	500.00	-50.00	-9.09
5	МОНГОЛЫН ЦАХИЛГААН	5,225	380.65	347.54	-33.11	-8.70
6	ТАЛХ ЧИХЭРХК	449	18000	16,450.00	-1,550.00	-8.61
7	БИНСЭ ХК	2	300	275.00	-25.00	-8.33
8	ГЕРМЕС ЦЕНТР	17,637	139.99	129.00	-10.99	-7.85
9	РЕМИКОН ХК	157,056	25.37	23.40	-1.97	-7.77
10	АТАР-ӨРГӨӨ ХК	10	65000	60,000.00	-5,000.00	-7.69
11	БАГАНУУР ХК	368	1087	1,005.00	-82.00	-7.54
12	МОНГОЛ ШЕВРО ХК	24	1200	1,126.00	-74.00	-6.17
13	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК	3,838	1306	1,230.00	-76.00	-5.82
14	ХАР ТАРВАГАТАЙ ХК	350	4766	4,500.00	-266.00	-5.58
15	МОНГОЛ САВХИ ХК	983	475	450.00	-25.00	-5.26

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК НЬ ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГААР ШАЛГАРЧ, “ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР ШАГНУУЛЛАА

Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газраас төрийн өмчит компаниудтай байгуулсан “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-г дүгнэж, гэрээний хэрэгжилтээр 95%-аас дээш үнэлгээ авсан 27 байгууллагад “ӨРГӨМЖЛӨЛ” гардуулж, тэдгээр байгууллагуудын 31 ажилтан, мэргэжилтнүүдийг “ЖУУХ БИЧИГ”-ээр шагналаа.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлж, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлж, “Үлгэр жишээ” дүгнэгдсэн тул Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын шилдэг байгууллагаар шалгарч “ӨРГӨМЖЛӨЛ” гардан авлаа.



"ЛЭНДМН ББСБ" ХК НИЙТ ГАРГАСАН ХУВЬЦААНЫ 5 ХҮРТЭЛХ ХУВИЙГ ХАЛААСЛАХААР ШИЙДВЭРЛЭСЭН БАЙНА

"ЛэндМН ББСБ" ХК нь Компанийн тухай хуулийн 49, 55, 76 дугаар зүйлд нийцүүлэн гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20/37 тоот тогтоолоор компанийн нийт гаргасан хувьцааны 5 хувь хүртэлх хэмжээний энгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс эргүүлэн худалдан авч, халааслахаар шийдвэрлэсэн байна.

Тогтоолын хавсралтад заасны дагуу компанийн гаргасан хувьцааны 5 хувь буюу 40 сая хүртэлх хувьцааг, тухайн арилжааны өдөр бүрийн өмнөх 30 хоногийн дундаж ханшийн 105 хувиас хэтрэхгүй үнээр 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд худалдан авахаар болсон бөгөөд энэ тухай долоо хоног бүрийн Баасан гарагт олон нийтэд мэдээлэхээр болсон байна.

"САНХҮҮГИЙН ИННОВАЦИ" ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ОРОЛЦЛОО

Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхим, ОХУ-ын Плехановын нэрэмжит ЭЗИС-ийн Улаанбаатар дахь салбар сургуультай хамтран зохион байгуулж байгаа 15 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурал "Санхүүгийн инноваци" сэдвийн хүрээнд явагдсан бөгөөд энэхүү арга хэмжээг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК дэмжин оролцож, Гүйцэтгэх захирал Х.Алтай "Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиг хандлага" сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлээ.

Энэ удаагийн хурлын онцлог нь анх удаагаа цахим хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд АНУ, Энэтхэг, Малайз, Итали, Япон, ОХУ-ын эрдэмтэн судлаачид, Дэлхийн банк, Азийн Хөгжлийн Банк зэрэг олон улсын байгууллагууд, Монгол банк, Санхүүгийн зохицуулах Хороо, Монголын хөрөнгийн бирж зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцож, Виртуал валют, финтек, хэрэглэгчийн санхүүгийн эмзэг байдал, төр хувийн хэвшлийн түншлэл, баялгийг хөшүүрэгдэх замаар институт, хувь хүмүүст хөрөнгө оруулах, орон сууцны зах зээл, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн хандлага, даатгалын технологи, системийн эрсдэл, тэтгэврийн шинэчлэл, татварын нөлөөлөл, цахим зээл, зээлийн зэрэглэл зэрэг сэдвийг хамарсан илтгэлүүд тавигдлаа.



"БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ УЦК" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЛЭЭ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/83 тоот тушаалаар "Блюскай секьюритиз УЦК" ХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүлэхээр боллоо.



Үйл явдал

"МАНДАЛ ДААТГАЛ" ХК НЬ AM BEST АГЕНТЛАГААС BB+ ҮНЭЛГЭЭ АВЛАА

Даатгалын болон давхар даатгалын компаниудад санхүүгийн зэрэглэл, үнэлгээ тогтоох үйл ажиллагаа явуулдаг AM Best агентлагаас "Мандал даатгал" ХК-ийн ерөнхий санхүүгийн чадавхийг "В", урт хугацааны зээлжих зэрэглэлийг "BB+" гэж тус тус үнэлсэн бөгөөд цаашдын төлөвийг нь "Тогтвортой" хэмээн үзжээ. Энэхүү зэрэглэлийг гаргахад компанийг олон талаас нь судалж, санхүүгийн үзүүлэлтүүд болон өмнөх хугацааны гүйцэтгэлийг "Strong" буюу "Хүчтэй" хэмээн тодорхойлсон байна.

AM Best нь 1899 онд байгуулагдсан, АНУ-д төвтэй, Нью Йорк, Лондон, Амстердам, Дубай, Хонконг, Сингапур зэрэг 100 гаруй улс орны томоохон хотуудад үйл ажиллагаа явуулдаг, санхүүгийн зэрэглэл, үнэлгээ тогтоох үйл ажиллагаа явуулдаг нарийн мэргэшсэн тэргүүлэгч агентлаг юм.

"ЖЕНКО ТУР БЮРО" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Женко тур бюро" ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 2-р сарын 19-ний өдрийн №01 тоот тогтоолоор 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 10 төгрөг буюу нийт 799.8 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн хэдий ч цар тахлын улмаас гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үүсч, компанийн нөхцөл байдал хүндэрсэн тул Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 08 тоот тогтоолоор нэгж хувьцаанд 1 төгрөгийн ногдол ашиг тараахаар өөрчлөн шийдвэрлэсэн байна.

Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр гаргах бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 31-ний дотор "ҮЦТХТ" ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэв.

"АСЕ ЭНД Т КАПИТАЛ ҮЦК" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 988 тоот тогтоолоор "АСЕ энд Т Капитал ҮЦК" ХХК-ийн хөрөнгө оруулалтын зөвлөх, брокерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тул "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/84 тоот тушаалаар "АСЕ энд Т Капитал ҮЦК" ХХК-ийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг 3 сарын хугацаатайгаар түдгэлзүүллээ.

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН"-ИЙН НИЙТ ГАРГАСАН ХУВЬЦААГ БҮРТГЭЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит хурлаар "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн"-ийн Канад Улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй 263,885,433 ширхэг хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэхээр шийдвэрлэлээ. Хувьцааг нэмж бүртгэснээр Монгол болон Канад Улсын иргэн, аж ахуйн нэгж өөрийн эзэмшлийн "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн"-ийн хувьцааг Торонтогийн бирж болон Монголын хөрөнгийн биржээр дамжуулан чөлөөтэй арилжаалах нөхцөл бүрдэж байна.

Ингэснээр гадаадын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үндэсний томоохон аж ахуйн нэгжүүд дотоодын биржид хувьцаагаа давхар бүртгүүлэх сонирхлыг нэмэгдүүлж, хөрөнгийн зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүний төрөл нэмэгдэх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хамгаалагдах, гадаадын хөрөнгө оруулалтыг дотоодын хөрөнгийн зах зээлд татах ач холбогдолтой үйл явдал боллоо.



Erdene Resource Development

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН" НЬ "ЛИДЕР ЭКСПОРЕЙШН" ХХК-ИЙГ ХУДАЛДАН АВЛАА

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" нь "Лидер Экспорэйшн" ХХК-ийн 49%-ийг худалдан авч, Баян Хөндий Алтны ордтой залгаа орших Улаан тусгай зөвшөөрлийн талбайг 100% эзэмшихээр болсон байна.

Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн баруун талд зэргэлдээ оршдог нийт 1,780 га талбайг хамардаг бөгөөд порфирын эс болон эпитеpmаль алтны

системийн шинж чанар бүхий кварц-серицит-пирит (QSP)-ийн хүчтэй хувирлын томоохон бүсийг (ойролцоогоор 3 км диаметр бүхий) агуулдаг.



ЗАРИМ ХУВЬЦААТ КОМПАНИЙГ ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.1, 3.2.10 дахь заалтууд, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11, “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 23 дугаар зүйлийн 23.11 дэх заалтууд болон СЗХ-ны Улсын байцаагчийн 2014 оны 11-р сарын 26-ны өдрийн 148 тоот албан шаардлага, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2018 оны 11-р сарын 06-ны өдрийн 11/3130 албан тоотыг тус тус үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/91 тоот тушаалаар үнэт цаасны арилжааг зогсоосноос хойш 6 жилээс дээш хугацаанд арилжаа сэргээгүй буюу арилжааг зогсоох нөхцөл шалтгаан нь арилаагүй “Хүнс-Архангай” ХК болон Улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлгүй “Эрдэнэт зандан” ХК-иудыг Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлээс хаслаа.

“СҮҮ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА ӨӨРЧЛӨГДСӨН БАЙНА

“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 17 тоот тогтоолоор тус компанийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Эрдэнэчимэгийг чөлөөлж, Гүйцэтгэх захирлаар М.Болодыг томилсон байна. М.Болод нь 2013-2019 онуудад “Сүү” ХК-ийн Маркетинг, борлуулалт, сүү бэлтгэл хариуцсан дэд захирлаар ажиллаж байсан байна.

“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Баянгол Зочид Буудал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 9-р сарын 30-ны өдрийн № 02 тоот тогтоолоор компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн төлөлтийг ирэх оны ногдол ашгийг төлөх хүртэл хугацаагаар хойшлуулахаар шийдвэрлэсэн байна. Энэхүү “Баянгол Зочид Буудал” ХК-ийн ТУЗ-ийн тогтоолыг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Монголын хөрөнгийн биржид ирүүлсэн байна.

“СИКАП ҮЦК” ХК-ИЙН АНДЕРРАЙТЕРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЭРХИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 979 тоот тогтоолоор “Сикап ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд андеррайтерын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Үйл явдал

"БОРНУУР" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХОЙШЛОГДСОН ХУРЛЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛНА

"Борнуур" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Борнуур сумын Соёлын төвд зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Монгол улсын Засгийн газраас орон нутгийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж, олон нийтийг хамарсан аливаа арга хэмжээ, хурал, цуглаан явуулах боломжгүй болсон тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахаар боллоо.

Хурлын бүртгэлийн өдөр: 2020.11.09

Хурал хуралдах огноо: 2020.12.23

Хурал эхлэх цаг: 11:00 цаг

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн санхүү үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах
3. Ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр
4. Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох

Холбоо барих утас: 88222323, 89114474

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА ОНЛАЙН ГОРИМООР ХЭВИЙН ЯВАГДАНА

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 226 дугаар тогтоолоор Ковид-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн зайнаас ажиллах горимд шилжих бөгөөд тус хугацаанд үнэт цаасны арилжаа хэвийн явагдана.

Засгийн газрын тус тогтоолын хавсралтаар шинэчлэн батлагдсан "Хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн жагсаалт"-нд хөрөнгийн бирж, түүнтэй холбогдох үйл ажиллагааг нэмж оруулах тухай хүсэлтийг зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд болох "ҮЦТХТ" ХХК болон "МҮЦКТ" ХХК-тай хамтран хүргүүлээд байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN